МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ

Илтгэгч: Д.Тогтохсүрэн /УИХ-ын гишүүн,
УИХ дахь МАН-ын бүлгийн дарга,
УИХ-ын “Төвлөрлийг сааруулах, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх” ажлын хэсгийн ахлагч/

Илтгэлийн агуулга

1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөлт

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Хотын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх заалт

Монгол Улсын Үндсэн хуулийн заалт

Тавин долдугаар зүйл

1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

Төслийн заалт

Тавин долдугаар зүйл

1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, хотод, аймаг нь сум, хот (орон нутгийн харьяалалтай)-д, сум нь багт, хот (орон нутгийн харьяалалтай) нь хороонд, нийслэл болон хот нь дүүрэгт, дүүрэг нь хороонд тус тус хуваагдана.

57.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Тавин наймдугаар зүйл

1.Аймаг, нийслэл, хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлагатай, засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бүхий, иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох эрхтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж мөн. Баг, хороо бол засаг захиргааны анхан шатны нэгж мөн.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Олон нийтийн санал авах үеэр эхний ээлжинд сум, дүүргийн Хурлын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлдэггүй байх санал давтамж өндөртэй тавигдсаныг үндэслэн нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах журамд оруулж байгаа өөрчлөлт:

Төслийн заалт

2.Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ, тухайн Хурлын чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

3.Аймаг, нийслэл, хотын ИТХ-ын төлөөлөгчийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно. Сум, дүүрэг, хот (орон нутгийн харьяалалтай)-ын ИТХ-ын төлөөлөгчийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугч иргэд сонгоно. Сум, дүүрэг, хот (орон нутгийн харьяалалтай)-ын ИТХ-ын сонгуульд гагцхүү иргэн өөрийн нэрийг дэвшүүлэн оролцоно.

4.Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мөн. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар тогтоох, өмчөө захиран зарцуулах эрхтэй байна.

5.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрт хамаарах асуудлаар хуульд заасан болон сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргана.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Олон нийтийн санал авах үеэр сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг сонгодог, аймаг, нийслэл, хот, баг, хорооны Засаг даргыг томилдог байх санал давтамж өндөртэй тавигдсаныг үндэслэн бүх шатны Засаг даргыг томилох, сонгохтой холбоотой оруулж байгаа өөрчлөлт:

Төслийн заалт

2. Аймаг, нийслэл, хотын Засаг даргыг тухайн нутгийн Хуралд танилцуулснаар Ерөнхий сайд, баг, хорооны Засаг даргыг сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг дарга дөрвөн жилийн хугацаагаар тус тус томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлж, огцруулна.

3.Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд дөрвөн жилийн хугацаагаар сонгож, аймаг, нийслэл, хотын Засаг дарга арван тав хоногийн дотор батламжилна. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргын сонгуульд иргэн хуульд заасны дагуу бие даан нэр дэвшинэ. Сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Хурал, Засаг даргын эрх мэдлийн хяналт, тэнцлийг хангахтай холбоотой заалт:

Төслийн заалт

60.4. Хуульд заасан үндэслэлээр аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар аймаг, нийслэл, хотын Засаг даргыг огцруулах саналыг Ерөнхий сайдад, баг, хорооны иргэдийн дөрөвний нэгээс доошгүй нь баг, хорооны Засаг даргыг огцруулах саналыг сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргад өргөн мэдүүлсэн бол арван тав хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ. Засаг даргыг огцруулах шийдвэр гаргасан тохиолдолд нөхөн томилох асуудлыг арван тав хоногийн дотор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

60.5. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг хуульд заасан үндэслэлээр огцруулах саналыг аймаг, нийслэл, хотын Засаг дарга сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Хуралд оруулсан бол арван тав хоногийн дотор уг асуудлаар Хурал шийдвэр гаргаж, хариу мэдэгдэнэ. Хурал сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг огцруулах шийдвэр гаргасан тохиолдолд бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг аймаг, нийслэл, хотын Засаг дарга томилно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөлт

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, УИХ-аар батлуулахаар ажиллаж байна.

- Өмнөх хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт гаргах
- Шинэ хуулийн төсөл бэлтгэгдэж байгаа
- Хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, батлуулах
- Хуулийн төсөл шинэлэг, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн, хотын асуудлыг тодорхой болгосон хууль байхаар төсөөлж буй.

Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага

УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран “Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ төслийн хүрээнд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өнгөрсөн 27 жилийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээг манай урдаа барьдаг, нутгийн удирдлагын чиглэлээр судалгаа хийдэг, мэргэшсэн баг ажиллаж дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтэд үндэслэн Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойллоо.

Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага

Тус багаас Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль нь зах зээлийн эдийн засгийн нөхцөлд орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрэн дүүрэн хангаж чадаагүй, нутгийн өөрөө удирдах байгууллагын мөн чанар, түүнд нийцсэн чиг үүрэг, бүрэн эрхийн зохицуулалтыг бүрэн хуульчилж чадаагүй, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрийн онцлог байдлыг бүрэн гаргаж тодорхойлоогүй, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрийн онцлог байдлыг бүрэн гаргаагүй, нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг дэлгэрэнгүй зохицуулж тодорхойлоогүй, үүний улмаас нутгийн удирдлагын шат шатны байгууллага, засаг даргын чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлон ялган зааглаж чадаагүй байна гэж дүгнэсэн.

Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөхөд харгалзан үзэх тодорхой үндэслэл шалгуурыг бий болгох шаардлагатай.
- Хотын эрх зүйн байдлыг тодорхой болгож, хотын удирдлага, захирагчийн бүрэн эрх, үйл ажиллагааг ИТХ, засаг даргын бүрэн эрхээс зааглах, хотын өмч, төсөв, хотын иргэдэд үйлчилгээ үзүүлэх эрх зүйн үндсийг бий болгох
- Нутгийн удирдлагын /ИТХ, засаг дарга/ гурван түвшинд чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлохдоо ихэвчлэн нийтлэг чиг үүрэг, бүрэн эрх гэдэг байдлаар зохицуулсны улмаас удирдлагын дээд шатны байгууллага нь доод шатны байгууллагын чиг үүрэг, бүрэн эрхийн асуудлыг шийдвэрлэх боломжтой болсон. ИТХ, Засаг даргын эрхлэх асуудлыг давхардуулсан зэргийг засаж, сайжруулах шаардлага байна.
- Төсөв, татвар, санхүүгийн дорвитой өөрчлөлт хийж, орон нутгийн бие даасан байдал, хариуцлага, санаачлагыг дээшлүүлэх шаардлага байна.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!